

ТӨРИЙН ЖИНХЭНЭ АЛБАН ХААГЧИЙГ ШИЛЖҮҮЛЭН АЖИЛЛУУЛАХ ТУХАЙ ЗАР

Төрийн албаны тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.2 дахь хэсэг, Төрийн албаны зөвлөлийн 2023 оны 25 дугаар тогтоолоор батлагдсан Төрийн албаны шалгалт өгөх болзол болон шатлан дэвшүүлэх, сонгон шалгаруулах журмын 4 дүгээр зүйлийн 4.2-т заасны дагуу төрийн өөр байгууллага, нэгж хооронд шилжин ажиллахыг хүссэн төрийн холбогдох бусад байгууллагад ажиллаж байгаа төрийн жинхэнэ албан хаагчдыг дараах албан тушаалд холбогдох материалаа цахим шуудангаар ирүүлэхийг урьж байна.

Тавигдах болзол, шаардлага:

- төрийн жинхэнэ албан тушаалд зохих ёсоор томилогдсон байх;
- зарлагдсан албан тушаалтай адил төрөл болон адил ангилалд ажилладаг байх;
- зарлагдсан албан тушаалын тодорхойлолтод заасан тусгай шаардлагыг хангасан байх.

Бүрдүүлэх материал:

1. Хүсэлт
2. Төрийн албан хаагчийн анкет;
3. Иргэний үнэмлэхийн хуулбар;
4. Боловсролын түвшинг тодорхойлсон баримт бичиг /диплом/, хэрэв гадаад улсад их, дээд сургууль төгссөн бол боловсролын баримт бичгийн баталгаат орчуулгыг хавсаргах;
5. Мэргэшүүлэх сургалтад хамрагдсаныг гэрчлэх баримт бичиг;
6. Нийгмийн даатгалын дэвтэр /Хөдөлмөрийн дэвтэр/-ийн хуулбар, цахим лавлагаа;
7. Албан тушаалд томилогдсон, чөлөөлөгдсөн тушаал, шийдвэрийн хуулбар;
8. Төрийн жинхэнэ албаны тангараг өргөсөн “Тангаргийн хуудас” хуулбар;
9. Сүүлийн гурван жилийн төрийн албан хаагчийн үйл ажиллагааны үр дүн, мэргэшлийн түвшинг үнэлсэн илтгэх хуудас, төрийн жинхэнэ албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний үнэлгээ;
10. Цэргийн жинхэнэ алба хаах үүрэг хүлээсэн иргэний хувьд цэргийн үүрэгтний үнэмлэх;
11. Иргэний эрүүгийн хариуцлага хүлээж байсан эсэх тухай тодорхойлолт /e-mongolia-с татан авах/.

Материал хүлээн авах:

- Хугацаа: 2024 оны 01 дүгээр сарын 19-ний өдрийн 18:00 хүртэл
- Хүлээн авах хаяг: arkhangai@masm.gov.mn цахим шуудангаар
- Холбоо барих утас: 70332952, 99334399

Шилжүүлэх, сэлгэн авах ажлын байрны жагсаалт:

№	Байгууллага	Дотоод нэгж	Албан тушаалын нэр	Оронт	Албан тушаалын		Албан тушаалд тавигдах тусгай шаардлага				Материал хүлээн авах байгууллагын албан ёсны имэйл хаяг, холбоо барих утасны дугаар
					төрөл	Ангилал, зэрэглэл	Боловсрол	Мэргэжил	Мэргэш ил	Туршлага	
1.	Архангай аймгийн Стандарт, хэмжил зүйн хэлтэс	Стандарт, хэмжил зүйн хэлтэс	Сорьцын хяналтын улсын байцаагч бөгөөд Ахлах мэргэжилтэн/ Хүний нөөц, дотоод хяналтын асуудал хариуцсан/	1	Гүйцэтгэх	T3-7	Бакалавр ба түүнээс дээш боловсролын зэрэгтэй байх	- Бизнес ба удирдахуй- /041, 042/ - Инженерчлэл, үйлдвэрлэл, барилга байгууламж /07/ - Мэдээлэл, харилцаа холбооны технологиуд/06/ - Биологи ба холбогдох шинжлэх ухаан /051/ - Хүрээлэн буй орчин /052/ - Хими /0531/	-	Туслах түшмэлийн албан тушаалд ажилласан бол давуу тал болно.	Arkhangai@masm.gov.mn 70332952 99334399